



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Лувсаннамсрайн ОЮУН-ЭРДЭНЭ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-21-55, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

2025 10 06 № ЗМХ-03/11546
танай _____-ны № _____-т

Хянан шалгах түр хороо байгуулах
тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан Тавантолгойн нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулж хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор дараах асуудлын хүрээнд хянан шалгах түр хороог байгуулах шаардлагатай байна. Үүнд:

1.Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Таван толгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

2.Стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

0000002

3.Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Таван толгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 13. хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

О.БАТНАЙРАМДАЛ

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Г.ДАМДИННЯМ
Т.ДОРЖХАНД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
Б.ЖАВХЛАН
Х.ЖАНГАБЫЛ
Б.ЖАРГАЛАН
Д.ЖАРГАЛСАЙХАН
С.ЗАМИРА

Б.ЗАЯАБАЛ
Ж.ЗОЛЖАРГАЛ
С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ
Ч.ЛОДОЙСАМБУУ
Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ
М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР
Ц.МӨНХБАТ
Л.МӨНХБАЯСГАЛАН
Т.МӨНХСАЙХАН
Б.МӨНХСОЁЛ
П.МӨНХТУЛГА
Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН
Б.НАЙДАЛАА
Н.НАРАНБААТАР
П.НАРАНБАЯР
М.НАРАНТУЯА-НАРА
Ч.НОМИН
О.НОМИНЧИМЭГ
Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Б.ТУЛГА

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Д.ҮҮРИЙНТУЯА

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН
Б.ЧОЙЖИЛСҮРЭН
Ө.ШИЖИР
Л.ЭНХ-АМГАЛАН
Б.ЭНХБАЯР
Ж.ЭНХБАЯР
Л.ЭНХНАСАН
Д.ЭНХТҮВШИН
Д.ЭНХТУЯА
М.ЭНХЦЭЦЭГ
С.ЭРДЭНЭБАТ
С.ЭРДЭНЭБОЛД
Р.ЭРДЭНБҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулсан Тавантолгойн нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулж хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг **“Таван толгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах үйл ажиллагаа, олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, холбогдох баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх”-ээр тогтоосугай.**

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны **тусгай шалгалтын хүрээ хязгаарыг** доор дурдсанаар тогтоосугай:

1/Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг ашиглах үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах;

2/Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгах;

3/Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг

дэвсгэрт байрлах стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Олонхийг төлөөлөн:

.....

.....

Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

.....

.....

Улсын Их Хурлын гишүүн

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

“ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх” гэж, Ашигт малтмалын тухай хуулийн 8.1.7-д “Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох болон ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх” бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр тус тус хуульчилсан.

Түүнчлэн, “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дэх заалтад “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байршилтай Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг орд (Тавантолгой ХК, Энержи ресурс ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна)-ыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тооцон, мөн тогтоолын 4 дэх заалтаар “Стратегийн ач холбогдол бүхий...Таван толгой...ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон байна.

Стратегийн ач холбогдох бүхий Тавантолгойн бүлэг ордтой холбогдох тусгай зөвшөөрлийг эзэмшдэг компаниудын үйл ажиллагаатай холбогдуулж олон нийтэд эргэлзээ төрүүлсэн, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байж болзошгүй мэдээлэл түгэж, нийгэмд бухимдал үүсгэж байна.

Энэхүү нөхцөл байдал нь тус ордын ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгаж мөн иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах шаардлагыг илэрхийлж байна.

Өөрөөр хэлбэл, Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх,

Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх нь чухал байна.

Иймд тус чиглэлээр Улсын Их Хурал хянан шалгах түр хороо байгуулж, зохих хяналт шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төслийн зорилго нь Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хянан шалгах түр хороо байгуулах буюу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайд нүүрс олборлох үйл ажиллагаа болон Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт хийх, Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордод хамаарах ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийж, иргэдийн мэдэх эрхийг хангахад чиглэнэ.

Иймд тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан агуулгыг бүрэн хамруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүтцийн дагуу дараах зүйлийг тусгана:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах үндэслэл болон түр хорооноос хэрэгжүүлэх тусгай шалгалтын сэдэв, түүний хүрээ хязгаар;

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн, ажиллах болон үр дүн санал дүгнэлтийг тайлагнах хугацаа;

3.Тогтоолыг дагаж мөрдөх хугацаа.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 34, 35, 36 дугаар зүйлд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Тогтоолын төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордтой холбогдуулж олон нийтийн мэдэх

эрхийг хангаж, иргэд Тавантолгойн бүлэг ордыг хамрах тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалт, эдийн засгийн үр өгөөж, нөөцтэй холбогдуулж бодит мэдээлэлтэй болно.

Мөн Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн нүүрсний бүлэг ордтой холбоотой мэдээлэл, дүн шинжилгээг нэгтгэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх” зарчим хангагдах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтад үндэслэн, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Энэхүү тогтоолын төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22-т заасны дагуу хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах болон төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийхийг шаардахгүй бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 4-т “Стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой, Тавантолгой, Цагаан суварга, Асгатын ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг эхний ээлжинд боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон бөгөөд мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын 1-д зааснаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байршилтай Тавантолгойн чулуун нүүрсний ордод Тавантолгой ХК, Энержиресурс ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулахаар заасан.

Гэвч стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайд нүүрс олборлох үйл ажиллагаа болон Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх нь эргэлзээ үүсгэсэн мэдээлэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байна.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн чулууны нүүрсний бүлэг ордод хамаарах ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах шаардлага үүсээд байна.

Иймд Тавантолгойн бүлэг ордод хамаарах MV-011952 дугаартай “Ухаа худаг” ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон бусад тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшигч хуулийн этгээдийн оруулсан хөрөнгө оруулалт, олборлосон нүүрс, үйл ажиллагаа, мөнгөн урсгалд дүн шинжилгээ хийх, Тавантолгойн бүлэг ордоос олборлосон нүүрстэй холбогдуулж байгуулсан оффтейк гэрээнүүд холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан агуулга болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан бүтэц бүхий 5 заалттай болно.

Тогтоолын төслийн 1 дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах үндэслэл болон түр хорооноос хэрэгжүүлэх тусгай шалгалтын сэдвийг, 2 дахь заалтаар тусгай шалгалтын хүрээ хязгаарыг, 3 дахь заалтаар хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг, 4 дэх заалтаар хянан шалгах түр хорооны ажиллах болон үр дүн буюу санал, дүгнэлтийг тайлагнах хугацааг, 5 дахь заалтаар тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох зохицуулалтыг тусгасан болно.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйл болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 34, 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагыг ханган боловсруулсан бөгөөд хуульд заасны дагуу Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордтой холбогдуулж олон нийтийн мэдэх эрхийг хангаж, иргэд Тавантолгойн бүлэг ордыг хамрах тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглалт, эдийн засгийн үр өгөөж, нөөц, байгуулсан оффтейк гэрээнүүдийн хэрэгжилттэй холбогдуулж бодит мэдээлэлтэй болно.

Мөн Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордтой холбоотой мэдээлэл, дүн шинжилгээг нэгтгэх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх” зарчим хангагдах нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22-т заасны дагуу “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахад хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах болон төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоолол хийхийг шаардахгүй бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

-----oOo-----